



26

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 05 өдөр


Дугаар 408

Улаанбаатар хот

Г Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дурмийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг тус Төв /Н.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтuya/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 271 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Н.УДВАЛ

216

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 05 өдрийн
108 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв /цаашид Төв гэх/ нь улсын хэмжээнд Цус сэлбэлтийн талаар мэргэжлийн тусlamж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий үйлдвэрлэл, шинжилгээ, сургалт, судалгаа явуулах төрөлжсөн лавлагaa төв /цаашид төв гэх/ байгууллага юм.

1.2. Төв нь улсын хэмжээнд чанарын шаардлага хангасан, аюулгүй, эмчилгээний өндөр идэвх бүхий цус, цусан бүтээгдэхүүнээр эмнэлгийн байгууллагуудыг хангах, цусны албаны бодлогыг хэрэгжүүлэх төрөлжсөн мэргэжлийн байгууллага юм.

1.3. Төв нь улсын хэмжээнд цус сэлбэлт судлалын чиглэлээр дүгнэлт гаргаж, зөвлөгөө өгөх дээд байгууллага мөн.

1.4. Төв нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.5. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын дагуу явуулна.

1.6. Төв нь Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 14210, Энхтайваны өргөн чөлөө 13 гэсэн хаягтай байна.

1.7. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Transfusion medicine" гэж орчуулна.

1.8. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв үйл ажиллагаанд даацах зарчмыг баримтална.

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих;
- Тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусlamж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх.

2.2 Төвийн эрхэм зорилго

Донор хадгалалтыг сайжруулж, эмчилгээнд шаардлагатай аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний тэгш, хүртээмжтэй хангамжийг бүрдүүлсэн, хүний нөөцийн чадавхийг олон улсын түвшинд хүргэсэн үйлдвэрлэл, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болоход оршино.

Гурав. Төвийн эрх, үүрэг.

217

3.1 Төв дараах эрхтэй.

3.1.1. Цус сэлбэлтийн талаар улсын хэмжээнд мөрдөх хууль, дүрэм, хөтөлбөр, стандарт, эмнэлзүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлэх зохиц хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

3.1.4. Судалгаа шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон Олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;

3.1.5. Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах;

3.1.6. Төв нь тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;

3.1.7. Төв нь хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.8. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх

3.2. Төв нь дараах үүрэгтэй.

3.2.1. Эмнэлгүүдийн захиалгаар эмчилгээний үр дүнтэй, аюулгүй, чанартай цус, цусан бүтээгдэхүүнийг хүрэлцээтэй хэмжээгээр үйлдвэрлэх

3.2.2 Цусны салбар төвүүдэд үйлдвэрлэж буй цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, цусны доноруудад болон цус сэлбэхийн өмнө хийгдэх шинжилгээ, цусны бүлэг, хувийн тохирооны лабораторийн шинжилгээнд чанарын хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргах;

3.2.3. Трансфузиологийн чиглэлээр тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.4. Цусны албаны үйл ажиллагааны чиглэлээр хөтөлбөр, стандарт, удирдамж, аргачлал боловсруулах

3.2.5. Цусны аюулгүй байдал, үйлдвэрлэлийн болон эмнэлзүйн цус сэлбэлт судлалын чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, доод шатны эруул мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах. Үүнд шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх;

3.2.6. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн болон лабораторийн шинжилгээний оношилгоо, бүтээгдэхүүний шинэ дэвшилтэй техник, технологийг нэвтрүүлэх;

3.2.7. Нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд цусны донорын үйлсийг сурталчлах чиглэлээр үндэсний хэмжээнд сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

3.2.8. Хүн амын дундах цусны донорын талаарх мэдлэг, хандлагыг судлах тогтолцоог бий болгон мэдээний санг бүрдүүлэх, төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах;

3.2.9. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим бүртгэл, мэдээллийг ашиглах, салбар төвүүдийг цахим хэлбэрээр мэргэжил арга зүйгээр хангах алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.10. Тухайн чиглэлээр үйлдвэрлэлийн болон эмнэлзүйн судалгаа шинжилгээг гүйцэтгэж, үйлдвэрлэл шинжилгээний оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;

3.2.11. Төв нь эрүүл мэндийн талаархи төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэн ажиллах;

3.2.12. Төв нь үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.13. Төв нь тусlamж үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч, шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирсэн санал, гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах,

3.2.14. Төв нь тухайн чиглэлээрээ болон байгууллагын үйл ажиллагаанд үндэсний болон олон улсын түвшний итгэмжлэл авсан байх;

3.2.15. Төв нь санхүү, төсвийн нээлттэй ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;

3.2.16. Төв нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.17. Төв нь ажиллагсадын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.18. Төв нь ажиллагсадын мэдлэг үр чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.19. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Төв нь дараах чиглэлээр лавлагаа тусlamж үзүүлнэ.

Лавлах үйлчилгээ: ЦССҮТ нь улсын хэмжээнд дараах чиглэлээр лавлагаа тусlamжийг үзүүлнэ. Үүнд:

1. Хүн амын дунд донорын сургалт, сурталчилгааг хийх, сургалтын материал, гарын авлага боловсруулан түгээх, мэргэжил арга зүйгээр хангах;

2. Цус, цусан бүтээгдэхүүний шинэ технологи нэвтрүүлэх;

3. Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи, аргачлал боловсруулах, түгээх;

4. Цусны салбар төвүүдэд үйлдвэрлэх боломжгүй болон ховор бүлгийн бүтээгдэхүүнийг шаардлагатай үед тээвэрлэх;

5. Цусны салбар төвүүдээс ирүүлсэн эргэлзээтэй сорьцонд цус сэлбэлтээр дамждаг халдвар илрүүлэх шинжилгээг хийж баталгаажуулах;

6. Цусны салбар төвүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дээжинд түүврээр чанарын шинжилгээ хийж баталгаажуулах;

7. Эмнэлгүүдийн захиалга, хүсэлтээр цусны АВО, резус, болон бусад ховор бүлэг тодорхойлох;

8. Цусны тохироо тохирохгүй үед хувийн тохироо тодорхойлох шинжилгээг хийн тохирсон бүтээгдэхүүнийг эмнэлэгт нийлүүлэх;
9. Цус сэлбүүлэх өвчтөний ийлдсэнд эсрэгбие илрүүлэх, дүйн тодорхойлох шинжилгээ, Эсрэгбиийн таньц тодорхойлох шинжилгээг хийж баталгаажуулах;
10. Кумбын шууд болон шууд бус урвал тавих шинжилгээг хийх;
11. Цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн шалтгааныг тогтоох шинжилгээ хийх;
12. Үндэсний хэмжээнд цус сэлбэлтээр дамждаг халдварт илрүүлэх болон цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх.

Дөрөв. Төвийн бүтэц, зохион байгуулалт

- 4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал болон түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.2. Төвийн ерөнхий захирал нь дэд захирал болон алба, тасаг нэгжийн удирдлагуудыг оролцуулан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.
- 4.3. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа, шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхий захирал батлана.
- 4.4. Төвийн Ерөнхий захирлын тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.
- 4.5. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон Санал гомдолын хороо болон бусад шаардлагатай хороог байгуулан ажиллуулна.
- 4.6. Ерөнхий захирлын эрх, үүрэг:
- 4.6.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;
- 4.6.2. Төвийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 4.6.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;
- 4.6.4. Дэд захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;
- 4.6.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийн тайланг байгууллагын хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд мэдээлэх;
- 4.6.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;
- 4.6.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр төвийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;
- 4.6.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах
- 4.6.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах

4.7 Төвийн дэд захирал

Дэд захирал нь төвийн дотоод үйл ажиллагаа, тасаг нэгжүүдийн уялдаа холбоог зохицуулна. Төвийн захирлыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар орлон ажиллана.

220

Дэд захирал нь хөдөө орон нутгийн цусны салбар төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

Тав. Төвийн санхүүжилт

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1. Улсын төсөв;
- 5.2. Эрүүл мэндийн даатгал;
- 5.3. Үндсэн /төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого, үйлчлүүлэгчийн захиалгаар хийх урьдчилан сэргийлэх үзлэг/ ба үндсэн бус үйл ажиллагааны орлого /байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хууль тогтоомжинд нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон ашиг, орлого гэх мэт/
- 5.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж;
- 5.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.6. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр;

Зургаа. Гадаад дотоод хамтын ажиллагаа

- 6.1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Ерөнхий захирал төлөөлнө.
- 6.2. Төвийн Ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Ерөнхий захирал шийдвэрлэнэ.
- 6.4. Төв нь Төрийн захиргааны төв байгууллагын удирдлагууд, газрын дарга настай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.
- 6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, бусад төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. ЦССҮТ-ийн удирдлага, тасаг нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг

7.1. Хяналт шинжилгээ, дотоод аудитын алба

Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, эмнэлзүйн эрсдэлийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, хяналт шинжилгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа сайжруулах зөвлөмж гаргах, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх аудитыг зохион байгуулах.

7.2. Санхүү бүртгэлийн алба

Байгууллагын нягтлан бodoх бүртгэлийг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа "Төсвийн хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай" хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцсэн харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах байдлаар зохион байгуулах. Мөн санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

7.3. Чанарын алба, Цусны сонор сээрэмжийн нэгж

Чанарын алба нь цусны албаны бүх үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, тусlamж үйлчилгээний чанарт дотоодын хяналт тавина. Цусны сонор сээрэмжийн нэгж нь улсын хэмжээнд цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийг бүртгэх, шалтгааныг тогтоох, эргэн мэдээлж, урьдчилан сэргийлэх, цус, цусан бүтээгдхүүний донорын судаснаас өвчтөний судас хүртэлх бүхий л ѿ шат, үйл ажиллагаанд гарч болох эрсдэлээс сэргийлэх тогтолцоог нэвтрүүлэх.

7.4. Донор, технологийн тасаг

Цусны донорын талаарх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, донор хадгалалтыг сайжруулах, донорын бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, цус сийвэн цуглуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, шинэ арга, технологи нэвтрүүлэх, стандартын дагуу чанартай цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн шинэ арга технологи нэвтрүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, стандартын дагуу зөв хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгүүдийг чанарын шаардлага хангасан аюулгүй, найдвартай цус, цусан бүтээгдэхүүнээр цаг тухайд нь хангах

7.5. Лавлагаа лабораторийн тасаг

Цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх болон цусны бүлэг тодорхойлох шинжилгээг стандартын дагуу бүрэн зөв хийх, үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ болон цусны ховор бүлгийн шинжилгээг стандартын дагуу бүрэн зөв хийх, шинэ арга технологи нэвтрүүлэх, цус сэлбэлтээр дамждаг халдвар илрүүлэх болон цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх, трансфузиологийн чиглэлийн лавлагаа тусlamж, үйлчилгээг үзүүлэх

7.6. Сургалт, эрдэм шинжилгээний тасаг

Тухайн чиглэлээр мэргэжил олгох болон дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах, эмч мэргэжилтнүүдийг мэргэжлийн сургалтанд хамруулах, олон улсын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цус сэлбэлтийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, судалгааны чиглэлээр мэдээний санг үүсгэх, өөрийн чиглэлээр олон улсад нэвтэрч буй цусны албаны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах

7.7. Нөөц хангамж үйлчилгээний тасаг

Байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах, байгууллагын хэмжээнд ирэх жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах, дээрх асуудлуудаар байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, төвийн болон албаны үйл ажиллагааны статистик тоон тайлан мэдээг нэгтгэн дүгнэх, тайлагнах, байгууллагын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, өөрийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх давтан сургах, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг

282

хэрэгжүүлэх, байгууллагын дотоод журам, хамтын гэрээг боловсруулахад оролцон хэрэгжилтийг хангах, байгууллагын барилга байшин, эд хогшил, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл, холбооны хэрэгсэл, цахим сүлжээ системийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тоног төхөөрөмж ашиглаж ажилладаг тасаг, нэгжүүдийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.


7.8. Сувилахуйн алба

Байгууллагын хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, шалган зааварлах, гүйцэтгэлд хяналт тавих, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал халдварт хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан арга хэмжээ авч ажиллах;

Найм. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1 Төвийн ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна.

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС
ХОЛБОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖИЛ
АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ**



- Мэргэжил арга зүйн шууд удирдлага
- - - → Мэргэжил арга зүйн шууд бус удирдлага

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 сарын 05...ны өдрийн ~~10:00~~ дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

Лус Сээлбэлт Судалын Үндэсний Төвийн бүтэц

